

Хамтарсан Кредит Олгох Механизмын**Хамтарсан хорооны дүрэм****Агуулга**

1. Зорилго	2
2. Хамрах хүрээ	2
3. Тодорхойлолт	2
4. Гишүүд	2
5. Харилцаа холбоо	3
6. Хурал	3
6.1. Хуваарь	3
6.2. Хурлын шийдвэр	3
6.3. Ирц	3
7. Цахим хэрэгсэл болон цахим хурлын шийдвэр	4
8. Хэл	4
9. Нарийн бичгийн дарга нарын газар	5
10. Гаднын дэмжлэг	5
11. Нууцлал	5
12. Хурлын тэмдэглэл	5
13. Ашиг сонирхлын зөрчил	5

1. Зорилго

1. Хамтарсан Кредит Олгох Механизмын Хамтарсан Хорооны дүрэм, журам (цаашид "ХХ" гэх) нь гишүүнчлэл, шийдвэр гаргах журам, Хамтарсан Кредит Олгох Механизм (цаашид "ХКОМ" гэх)-ын Хамтарсан Хорооны үйл ажиллагааг тодорхойлно.

2. Хамрах хүрээ

2. Үйл ажиллагааны дүрэм, журам нь Хамтарсан Кредит Олгох Механизмыг Хэрэгжүүлэх дүрмийн С хэсэгт заасан үйл ажиллагааг оролцуулан, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүйгээр Хамтарсан Хорооны бүх үйл ажиллагаанд хамаарна.

3. Тодорхойлолт

3. Үйл ажиллагааны дүрэм, журмын нэр томъёог ХКОМ-ын Нэр томъёоны тайлбар тольд тодорхойлсон.

4. Гишүүд

4. Хамтарсан Хороо нь Японы тал болон Монголын талын төлөөлөгчдөөс бүрдэнэ.
5. Хамтарсан Хорооны гишүүдийг Тал тус бүрээс томилж, томилсон тухайгаа нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ. Тал тус бүрээс томилсон Хамтарсан Хорооны гишүүдийн тоо 10-аас илүүгүй байна. Хоёр тал урьдчилан бичгээр мэдэгдэж, зөвшөөрөгдсөн тоонд багтсан тохиолдолд гишүүдийн тоог хэдийд ч нэмэгдүүлэх, цөөрүүлэх, өөрчлөх боломжтой.
6. Хамтарсан Хорооны гишүүд Хамтарсан Хороогоор хэлэлцэж буй аливаа асуудалд хувийн болон санхүүгийн шууд ашиг сонирхолгүй байх ёстой.
7. Хамтарсан Хороо нь Монголын тал болон Японы тал тус бүрээс харилцан мэдэгдсэний үндсэн дээр томилогдсон хоёр талын даргатай байна. Хамтарсан Хорооны дарга чөлөөлөгдсөн тохиолдолд, түүнийг томилсон тал түүнийг орлох даргыг томилно.
8. Хамтарсан Хорооны дарга Хамтарсан Хорооны гишүүдээс Хамтарсан хорооны даргын үүргийг гүйцэтгэх нэг гишүүнийг томилж болно.

Томилогдсон талаарх мэдэгдлийг цахим хэлбэрээр эсвэл бичгээр мэдэгдэнэ.

5. Харилцаа холбоо

9. Талууд аливаа мэдэгдлийн талаар Монголын талаас Байгаль орчны асуудал эрхэлсэн төв байгууллага, Японы талаас Монгол Улсад суугаа Япон Улсын Элчин Сайдын яамаар дамжуулан харилцана.
10. 9 дэх хэсгийг үл харгалзан, хоёр тал ХКОМ-ын хэрэгжилтийн үйл ажиллагааны асуудлаар талуудаас томилсон үйл ажиллагааны үндэсний зохицуулагчаар дамжуулан хоорондоо харилцана.

6. Хурал

6.1. Хуваарь

11. Хамтарсан Хороо шаардлагатай гэж үзвэл жилд нэгээс доошгүй удаа хуралдана.
12. Нарийн бичгийн дарга нарын газар хурал бүрийн товыг хурал болохоос хоёр долоо хоногийн өмнө Хамтарсан Хорооны дарга нартай зөвшилцөн мэдэгдэнэ.
13. Нарийн бичгийн дарга нарын газар нь хурал бүрийн хэлэлцэх асуудлыг хурал болохоос хоёр долоо хоногоос доошгүй хугацаанд, хурлын баримт бичгийн эцсийн төслийг хурал болохоос ажлын таваас доошгүй хоногийн өмнө Хамтарсан Хорооны Дарга нартай зөвшилцөн бэлдэнэ.

6.2. Хурлын шийдвэр

14. Шийдвэрийг Хамтарсан Хороо зөвшилцөж батална.
15. Хамтарсан Хорооны дарга нар зөвшилцөлд хүрсэн эсэхийг тогтооно. Хамтарсан Хорооны гишүүний санал болгож буй шийдвэрийг эсэргүүцсэн тохиолдолд Хамтарсан Хорооны дарга нар зөвшилцөлд хүрээгүй гэж үзэн мэдэгдэнэ.

6.3. Ирц

16. Хамтарсан Хорооны хуралд тухайн талын Хамтарсан Хорооны гишүүн бүрийг орлох хүн оролцож, Хамтарсан Хорооны гишүүний үүргийг гүйцэтгэж болно. Орлох хүний талаарх мэдэгдлийг хурал болохоос өмнө цахим хэлбэрээр эсвэл бичгээр мэдэгдэнэ.
17. Хамтарсан Хорооны хуралд Хамтарсан Хорооноос өөрөөр шийдвэрлэснээс бусад тохиолдолд хоёр талаас зөвшөөрсөн ажиглагчид оролцох боломжтой.

7. Цахим хэрэгсэл болон цахим хурлын шийдвэр

18. Хамтарсан Хороо дараах үйл ажиллагааг хангасан тохиолдолд цахим хэрэгслээр шийдвэр гаргаж болно:
 - (a) Хамтарсан Хорооны дарга нар санал болгож буй шийдвэрийг Хамтарсан Хорооны бүх гишүүдэд цахим хэрэгслээр тараана.
 - (b) Санал болгож буй шийдвэрийг дараах тохиолдолд баталсан гэж үзнэ,
 - (i) Санал болгож буй шийдвэрийг тарааснаас хойш хуанлийн 10 хоногийн дотор Хамтарсан Хорооны гишүүдээс цахим хэрэгслээр сөрөг мэдэгдэл ирүүлээгүй, мөн Хамтарсан Хорооны дарга нар цахим хэрэгслээр баталгаажуулсан мэдэгдэл хийсэн, эсвэл
 - (ii) Хамтарсан Хорооны бүх гишүүд цахим хэрэгслээр баталгаажуулсан мэдэгдэл хийсэн.
19. Хамтарсан Хорооны аль нэг гишүүн сөрөг мэдэгдэл гаргасан тохиолдолд тухайн гишүүний саналыг Хамтарсан Хорооны дарга нар харгалзан үзэж, зохих арга хэмжээ авна.
20. Хамтарсан Хороо цахим хэрэгслээр шийдвэр гаргахад туслах зорилгоор цахим хурал хийж болно.

8. Хэл

21. Хамтарсан Хорооны хурлын шийдвэрийг Англи хэл дээр нийтэлнэ.

22. Хамтарсан Хорооны ажлын хэл нь Англи хэл байна. Хамтарсан Хорооны гишүүд бусад хэлээр ярих, материал тараах хүсэлтэй байх тохиолдолд Англи хэл рүү шууд орчуулах хүн болон орчуулгыг хөрвүүлэх боломжийг олгоно.

9. Нарийн бичгийн дарга нарын газар

23. Нарийн бичгийн дарга нарын газар нь Хамтарсан хороонд ажиллах бөгөөд Хамтарсан хороонд шаардлагатай ажлыг гүйцэтгэнэ.

10. Гаднын дэмжлэг

24. Хамтарсан Хороо нь чиг үүргээ хэрэгжүүлэхэд тусламж авах шаардлагатай тохиолдолд бүрэлдэхүүн хэсгийг байгуулж болно. Бүрэлдэхүүн хэсгийн дүрэм, журмыг Хамтарсан Хороо шийдвэрлэнэ.

25. Хамтарсан Хороо ажлынхаа нэг хэсэгт туслуулах зорилгоор тухай бүрд гаднын шинжээчийг томилох шийдвэр гаргаж болно.

11. Нууцлал

26. Хамтарсан Хорооны гишүүд, Нарийн бичгийн дарга нарын газар, эсвэл Хамтарсан Хороонд туслах үүрэг хүлээсэн бусад байгууллага, хүмүүс үүрэгт ажлын хүрээнд олж авсан мэдээллийн нууцлалыг хүндэтгэх, зүй бусаар ашиглах, гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүргийг хүлээнэ.

12. Хурлын тэмдэглэл

27. Хамтарсан Хорооноос гарсан шийдвэрүүдийг бүрэн эхээр нь шийдвэр гарсны дараа шууд олон нийтэд нээлттэй болгоно.

13. Ашиг сонирхлын зөрчил

28. Хамтарсан Хорооны хурал, цахим хуралд оролцож буй төрийн албан тушаалтнаас бусад аливаа байгууллага, хүмүүс үйл ажиллагаанд оролцохоос өмнө мэргэжлийн, санхүүгийн болон бусад ашиг сонирхол байхгүй гэдгээ мэдэгдэх бөгөөд энэ нь: i) Хамтарсан Хорооны өмнө

хүлээсэн үүрэг нь үйл ажиллагааг бодитоор хэрэгжүүлэхэд ноцтой хохирол учруулах, эсвэл ii) ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийн хуудсанд гарын үсэг зурснаар аливаа хүн, байгууллагад шударга бус давуу байдал бий болгох зэрэг зөрчил үүсгэхгүй байх. Тухайн хүний бодит байдалд эргэлзэхэд хүргэж болох нөхцөл байдал, эсвэл шударга бус давуу тал бий болгож болзошгүй эсэх зэрэг нь ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэх үндэслэлтэй.